

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-17</i>

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	3-17
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны 08 дугаар сарын 29-ний
өдөр /Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 53.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 23 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Мөнхбат, Ч.Номин;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Анар, Э.Батшугар, А.Ганбаатар.

Нэг. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ч.Тавинжил, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, мөн яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Борхүү, Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга Д.Батбаяр, Цахим засаглалын хэлтсийн дарга Б.Золбоо, Төсвийн ерөнхий нягтлан бодогч С.Лхам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, И-Монгол академи УТҮГ-ын захирал Б.Мягмарнаран, Үндэсний дата төв УТҮГ-ын захирал М.Баттулга, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мөнхбат, Монгол шуудан ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Тэлмэн, Монголын цахилгаан холбоо ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Чинбат, Мэдээлэл технологийн үндэсний паркийн захирал Ж.Золзаяа, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Д.Нямжаргал, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер П.Чанцалдулам, мөн газрын ахлах аудитор Д.Мөнхжин, А.Даваадорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх танилцуулгыг Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Б.Тулга, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Ж.Галбадрах, Ч.Ундрэм, С.Цэнгүүн нарын тавьсан асуултад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, И-Монгол академи УТҮГ-ын захирал Б.Мягмарнаран, Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ч.Тавинжил, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Ж.Золжаргал үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 50 минут үргэлжилж, 13 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 61.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 13 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их засаг” танхим,
15 цаг 23 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Байнгын хорооны эрхэм гишүүдийн мэндийг хүргэе.

Ирц бүрдсэн учраас 53,8 хувьтай бүрдсэн байна.

Тэгэхээр Байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудал.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 23 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлэх ёстой.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл, тайлбар өгөх ажлын хэсгийн гишүүдийг урьж байна.

Ажлын хэсгийн гишүүддээ ирц бүрдэлтээс болоод удтал хүлээлгээнд уучлал хүсэж байна.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрс энд бүртгүүлснээр тийм, мэдэж байгаа бол Лувсаньямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн

засгийн хөгжлийн сайд, Сангийн сайд Болдын Жавхлангийн оронд танилцуулга хийхээр Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, сайд Тулга ирсэн байгаа. Монгол Улсын Үндэсний Ерөнхий аудитор Загджав, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Цэндийн Баатархүү, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Алтан-Од ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Гэрэлбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Анар, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сонор, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Тулга, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Мөнхсүх, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч Цаирал, ингээд Сангийн яамны төлөөллүүд, зарим нь бас өөр Байнгын хороод дээр байгаа байх.

Үндэсний аудитын газар, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан тушаалтнууд тайлбар өгөхөөр мэдээлэл өгөхөөр ирсэн байна. Та бүхэнд баярлалаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 23 оны гүйцэтгэл, Засгийн газрын 23 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 23 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Тулга танилцуулна. Тулга сайдын микрофоныг нээж өгнө үү.

Б.Тулга: Та бүгдийнхээ энэ өдрийн амар амгаланг эрвэ.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 08 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцын нийт 19 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл дээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 362,8 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, урсгал зардалд 54,3 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 308,5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 83,3 хувь буюу 302,4 тэрбум төгрөгийг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, 16,7 хувь буюу 60,4 тэрбум төгрөгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцын зарлага эзэлж байна.

Улсын төсвөөс 357,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 13,3 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Та бүхэн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү. Анхаарал хандуулсан баярлалаа.

Ж.Золжаргал: Тулга сайдад баярлалаа.

Загджав дарга ирчихсэн байна. Одоо 23 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. 3 дугаар микрофон нээж өгнө үү.

Д.Загджав: Та бүхэнд энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

1. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 12 тайлан нэгтгэгдсэнээс 10 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 2

байгууллагыг аудитын түүвэрт хамруулаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай харьяа 8 байгууллагад өөрчлөлтгүй, 2 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 17 тэрбум төгрөгийн 67 зөрчил илэрснээс 7,8 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 4,8 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгаж, 30 албан шаардлага хүргүүлж 8,7 тэрбум төгрөгийн зөрчилд 23 зөвлөмж өгч, 3,5 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 3 албан шаардлага хүргүүлсэн.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 5,5 тэрбум төгрөгийн 26 алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 14,4 тэрбум төгрөгийн 17 зөрчил илэрснээс 14,2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага хүргүүлж, 0,2 тэрбум төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 24,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 21,6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төсөл, арга хэмжээний санхүүжилт 91 хувийн гүйцэтгэлтэй байна.

2. Шинжлэх ухаан технологийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын нийт 3,9 тэрбум төгрөгийн 12 зөрчил илэрснээс 3,9 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага хүргүүлж,

72,3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 0,2 тэрбум төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 0,8 тэрбум төгрөгийн 7 зөрчил илэрснээс 0,8 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өглөө.

Тус Байнгын хороо аудитын дүн, дүгнэлтээс үндэслэн дараах асуудалд анхаарал хандуулахыг зөвлөж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах,

Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн болон олон жилийн насжилттай эзэн холбогдогчгүй болж, найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авах,

Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулах,

Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, журмыг зөрчиж өөр компаниар ажлыг гүйцэтгүүлсэн, зардлын дээд хязгаарыг хэтрүүлсэн, гэрээний үүргийг хангуулаагүй, төслийн үр дүнгийн тайланг хугацаанд нь хүлээн авч

дүгнээгүй, төслийг хааж тайлан хүлээж авахдаа анхан шатны баримтыг бүрдүүлээгүй, хяналт хэрэгжүүлээгүй зөрчлүүдийг арилгах,

Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажиглах,

Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлтийг тоймлон танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа. баярлалаа.

Ж.Золжаргал: Танилцуулга хийж мэдээлэл өгсөн Тулга сайд, Загджав даргад баярлалаа.

Одоо асуулт хариулт эхэлнэ.

Дэгээр асуулт асуух хугацаа 3 минут, хариулт 4 минут, тус бүр 1 минутын нэмэлт хугацаа болон тодотгол хийх боломжтой байгаа.

Ингээд Байнгын хорооны гишүүдээс ажлын хэсгээс асууж, тодруулах асуулттай хүмүүс байна уу? Асуулт авах хүмүүсийн нэрийг авч тасаллаа. Цэнгүүн гишүүн, Ундрам гишүүн, Галбадрах гишүүн, Соронзонболд гишүүн.

Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Сайн байцаана уу? Нөгөө нэг юуны Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан дээрээс холбоотойгоор И-Монголиа гээд том систем хөгжүүлчихсэн байгаа. Энэ систем маань ерөнхийдөө 23 оны байдлаар ямаршуу өртөгтэй, аль агентлагийн гэх юм уу, харьяалалд байдаг ийм, яг хөрөнгө нь хаана бүртгэлтэй байдаг юм бэ гэж 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт болохоор ерөнхийдөө ингээд нөгөө энэ төсвийн гүйцэтгэл, энэ санхүүгийн нэгдсэн тайлангийн юуг танилцахаар энэ Засгийн газрын нөгөө нэг энэ яамд болгоны нэгдсэн ер систем байдаг юм болов уу, үгүй юм болов уу гэсэн нэг тийм асуулт байгаад байгаа байхгүй юу.

Яагаад гэхээр ингээд ихэнх Байнгын хороон дээр хүмүүс асуулт асуухаар заавал нөгөө нэг тухайн яамны Сангийн яамнаас эд нар нэгдсэн тайлангаа гаргаж харахаасаа илүүтэй хүн нь байж байж хариулах гээд байдаг. Тэгтэл хэрвээ нэгдсэн ер систем байдаг бол уг нь илүү амархан хариулахаар л юм шиг санагдаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ер нь бүтэц нь ер нь ямаршуу байдаг юм болоо гэсэн нэг тийм асуулт бас байгаад байгаа юм.

Ж.Золжаргал: Баярлалаа Баатархүү сайд хариулах уу? Баатархүү сайдын микрофоныг нээж өгнө үү.

Ц.Баатархүү: Сайн байцаана уу. Тэгээд Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

2023 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж байна. Манай яамны харьяа газрууд, төсөвт үйлдвэрийн газруудын удирдлагууд бүгдээрээ хүрэлцэн ирсэн байгаа. Ер нь И-Монголиа УТҮГ бол төрийн ү үйлчилгээг цахимаар иргэдэд үйлчлэх зорилготойгоор ингэж байгуулагдсан. УТҮГ гэдэг статустай явж байгаа.

Нийтдээ 90 гаруй системтэй, давхардсан тоогоор 1200 орчим төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлдэг ийм төсөвт үйлдвэрийн газар байдаг. Тэгээд Мягмарнаран дарга дэлгэрүүлээд 2020 оны төсөв санхүүтэй холбоотой зүйлүүдийг нэмээд танилцуулах ёстой гэж бодож байна.

2 дугаарт нь, бид нар ирэх 7 хоногийн Засгийн газрын хурлаар Монгол Улсын яам, төрийн байгууллагууд, агентлагуудын бүх мэдээллийг нэг цонхноос авч болох нэгдсэн тийм цахим шийдлийг танилцуулж байгаа. Энэ бол дэлхийн бүх улсууд ийм болчихсон. Яам, агентлаг болгон тусдаа систем хөгжүүлээд байдаг. Иргэд хайж олоход хэцүү байдаг. Харааны бэрхиээлтэй хүн мэдээлэл авахад хэцүү байдаг. Энэ ингээд мэдээллийн шинжтэй зүйл байгаа.

2 дахь зүйл нь бүх гүйцэтгэл нь харагддаг, хэдэн хүн төрийн үйлчилгээ авч байгаа юм. Өнөөдөр гурилын үнэ ямар байгаа юм, инфляц ямар байгаа юм бэ гээд ингээд шууд таблетаар угсраад бүх мэдээллээ харагддаг байдлаар юуны түрүүнд Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлын гишүүдэд, бүх Монгол Улсын энэ мэдээллийг нэгтгэж өгөх нэг цонхны Dashboard-ыг хийгээд явж байгаа.

Тэгэхээр Засгийн газрын 100 хоногт яамны зүгээс ийм мэдээллүүдийг бэлтгэж, шийдвэр гаргагч нарт нэг цонхоор бүх мэдээллээ хараад явах, амар болох болно гэж бодож байгаа.

Зүгээр Соронзонболд гишүүн тухайлах юм бол энэ төсвийн гүйцэтгэлийг харах Dashboard асууж байх шиг байна. Түүн дээр Сангийн яамныхан бас хариулаарай гэж хэлмээр байна.

Ж.Золжаргал: 3 дугаар микрофон, Мягмарнаран дарга, микрофон нээж өгнө үү.

Б.Мягмарнаран: Сайн байна уу? Гишүүний асуултад хариулъя.

И-Монгол академи УТҮГ-ын талаарх мэдээллийг Баатархүү сайд ерөнхийдөө өгчихлөө. Манай байгууллагын хувьд ер системийг хөгжүүлж явж байгаа. Бид нар ер e-tongolia гэдэг системийг хөгжүүлж, одоогоор 2600 орчим байгууллагын 48

мянган төрийн албан хаагч холбогдсон ашиглаж байгаа.

Гэхдээ бид нар ерөнхийдөө нөгөө төрийн байгууллагууд маань өөрсдөө ялгаатай ер системүүдийг ашигладаг. Өөрөөр хэлбэл хувийн хэвшлийн, зарим нь болохоор өөрсдөө хөгжүүлсэн системүүд байдаг. Нийт улсын хэмжээнд 14 төрлийн ер систем ашиглагдаж байгаа.

Бид нар төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд аль ер системийг ашиглаж байгаагаас үл хамаараад төрийн байгууллагууд хоорондоо албан бичиг солилцох нөхцөлийг бүрдүүлэхээр бид бүхэн досх гэдэг систем хөгжүүлсэн байдаг. Одоогоор досх систем дээр 1907 байгууллага холбогдсон. Төрийн байгууллагууд хоорондоо албан бичгийг 100 хувь цахимаар явуулах боломж бүрдчихээд байгаа. Үүнтэй холбоотой бас шийдвэр бас гарах байх.

Ж.Золжаргал: Та хариултаа авав уу? Тийм. Сангийн яамнаас. Та 1 дээр очоод суучих, тийм ээ. 1 номерын микрофон нээж өгнө үү.

Сангийн яамны ТЗУГ-ын дарга Тавинжил Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан, тэгээд дээр нь нэмээд энэ төсвийн гүйцэтгэлийг Сангийн яам хариуцаж, нэгтгэж ажилладаг байгаа. Төсвийн гүйцэтгэлийн хувьд сар болгон төсөвт байгууллагуудын манай дээр нэгдсэн 1 системтэй. Гүйцэтгэлээ байгууллага болгон нь өөрсдөө оруулж шивдэг ийм программ ажилладаг. Энэ гарсан гүйцэтгэлээ бид нар Үндэсний статистикийн газарт хүргүүлээд, ингээд түүгээр тодорхой мэдээлэл нь нийтэд ил тод байхаар зохион байгуулагдсан байгаа.

Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг нэгтгэдэг e-tailan гээд

систем байгаа. Энэ дээр төсөвт байгууллагууд төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрсдөө тайлангаа шивж оруулаад. ингээд манай дээр нэгтгэгдээд нэгдсэн байдлаар ингээд жилийн эцсээр Үндэсний Аудитын газарт хүргэгдээд. ингээд Засгийн газар, Их Хуралд танилцуулагддаг ийм байна систем. Энэ систем яг төсвийн байгууллагууд өөрсдөө хариуцагч яамд л нэвтрэх эрхтэй болохоос яг хөндлөнгөөс одоохондоо нэвтрэх тийм эрх байхгүй байгаа.

Саяын Баатархүү гишүүний тэр нэг цонхны систем гэдэг систем хөгжөөд явах юм бол үүнийг тийш нэгтгээд оруулчих бололцоотой. Тэгээд хүн болгонд нээлттэй болчих тийм бололцоо байгаа гэж үзэж байгаа.

Ж.Золжаргал: Тодруулга Соронзонболд гишүүний микийг нээж өгнө үү.

Л.Соронзонболд: Би нөгөө И-Монголиа систем чинь ерөнхийдөө ингээд та хэд маш олон систем хөгжүүлээд, аягүй их хөрөнгө оруулалт хийсэн байна шүү дээ, тийм ээ. Маш олон хүн ажиллаж байна. Өртөг зардал нь хэд болсон юм бэ? Хөрөнгийн бүртгэл нь хаана, хэн дээр байдаг юм бэ гэж асуусан шүү дээ.

Ж.Золжаргал: 3 номер.

Б.Мягмарнаран: и-монгол системийг хувийн хэвшилээр яг анх захиалж хийлгэсэн байдаг. Төсөвтэй холбоотой анх захиалж хийлгэсэн төсөвтэй холбоотой мэдээллийг гишүүнд хүргүүлэе. Зарим нь төслийн хэлбэрийг нөгөө нууцын төсөл байдлаар зохион байгуулсан байдаг.

Одоо бол бид бүхэн 7,6 тэрбумын жилийн төсөвтэйгөөр, тэгээд 7,2 тэрбумын гүйцэтгэлтэйгээр 2023 онд ажилласан байгаа. Цэвэр улсын төсвөөс ажиллаж байна.

Ж.Золжаргал: Баярлалаа. Галбадрах гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Ж.Галбадрах: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны дарга болон гишүүддээ бас мэнд хүргэе.

Надад нэг 2 асуулт байна. Бас л И-Монголиа-тай холбоотой. Манай төрийн үйлчилгээ маань ийм дижитал шилжилт хийгээд, тэгээд 2021 онд Кибер аюулгүй байдлын хууль гэж гарсан байдаг. Тэгэхээр энэ мэдээлэл маань маш их том дата үүсгээд ингээд явж байна.

Тэгээд энэ аюулгүй байдал талаас нь, нууцлал талаас нь ер нь төсөвт хэчнээн төгрөг төлөвлөж байдаг юм, тэрийг яаж хамгаалж, яаж зарцуулж байдаг талаар 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт нь, энэ хиймэл оюун ухаан гээд яригдаж байгаа энэ хувийн компаниуд ч гэсэн нэлээн хийгээд энэ Эгүнэ энэ тэр гээд л оруулж ирсэн байдаг шүү дээ. Энэ Болор софт энэ тэрийн. Тэгээд тэнд Боловсролын яам энэ тэр дээр бас Виртуал багш энэ тэр гээд багшийн туслах тийм ээ, сурагчийн туслах, сурагчийн багш энэ тэр гээд юунууд ороод ирчихсэн байж байдаг.

Тэгээд энэ компаниудтай ер нь ингээд тэр талынх нь юмыг нь санхүүжилт энэ тэр нь яаж хийгдээд, үүнийг дэлгэрүүлэх тал дээр төсөв мөнгөнд яадаг юм бол? Тэгээд Боловсролын яам маань энэ тал дээр гэрээ хийчихсэн. Эхлээд ямар ч байсан бүх багш, сурагчид энэ гүүглийн аккаунттай ингээд болчихсон юм байна лээ. Тэгээд бас нэг дугаартай, нэртэй.

Тэгээд би жишээлбэл энэ төсөл хэрэгжүүлээд явахад тэр мэйл хаяг юугаар нь ингээд яг оролцсон сургуулиудтайгаа яваад, сургалтынхаа юмыг ингээд хянаж бас болоод байгаа. Тэгээд үүнийг бас дэлгэрүүлэх тал дээр төсөв мөнгө энэ тэр нь ямар байдаг юм

бол? Энэ их сайн туршилага шиг надад бас санагдаад байгаа юм.

Нөгөө талаас бас тэр Гүүгл компани бас ороод ирчихсэн. Яаман дээр бас багш, сурагчдын гээд бүгдэд нь энэ аккаунт өгөөд, ингээд явж байгаа юм байна лээ. Үүнийг цаашидаа бүх байгууллагуудад хүртээмжтэй явуулах талын тэрэнтэй ямар холбоотой яаж ажилладаг юм гэдэг талаас нь бас сонирхож байна.

Ж.Золжаргал: 3 тусдаа асуулт гэж ойлголоо. Баатархүү сайдын микрофоныг өгнө үү.

Ц.Баатархүү: Баярлалаа. Гишүүний асуултад хариулъя. Ер нь бас Байнгын хорооны гишүүддээ ер нь нэгдсэн ойлголттой байх үүднээс энэ Гүүгл компанитай хамтарсан төсөл Монгол Улсад хэрэгжиж байгаа. Яам болгон яг өөр өөрсдийн чиглэлээр захиалга өгөөд, бас ингээд хамтын ажиллагаануудыг өрнүүлдэг.

Юун түрүүнд 1000 инженер бэлтгэх төсөл өнгөрсөн хавар эхлээд амжилттай явж байгаа. Мэдээлэл технологийн ИТ паркаа түшиглээд явж байгаа. 350 инженерийг эхний ээлжид бэлдсэн. Монгол Улсад хамгийн эрэлттэй байгаа энэ инженерүүдийг бэлтгэж, гүүглийн эхний шатны сертифайд өгөх энэ ажлууд явж байгаа.

Боловсролын яам дээр явж байгаа нэг том төсөл та бүхэн мэдэж байгаа байх. Ер нь энэ цахим шилжилтийг хийхийн тулд ЕБС-ийн багш нарын энэ мэдлэг, ур чадварыг апдэйт хийж сайжруулах ийм шаардлага байгаа. Тэгээд 35 мянган багшийг мэргэжил дээшлүүлж сургах энэ төсөл явж байгаа. Энэ Боловсролын яамтай хамтраад ажиллаж байгаа.

2 дугаарт нь, и-монголиа, и баримт ч гэх юм уу энэ их кодууд бүгдээр төрийн өмч, код нь бол. Энэ кодуудыг

бид нар ижил төстэй улс орнуудад борлуулаад, экспорт хийгээд, старт апуудыг дэмжих, энэ сандаа мөнгө төвлөрүүлэх ийм боломжтой болсон хуулийн боломжтой болсон. Тэгэхээр ингээд яамнууд, төрийн байгууллагууд, агентлагууд маш их софтвэр хөгжүүлдэг. Энэ софтвэрийнхээ эх кодыг бид нар бусад өөр улсад санал болгоод, борлуулаад, ингээд төсөвт мөнгө төвлөрүүлэх ийм бас боломж хуулийн боломж бүрдсэн шүү гэдгийг та бүхэнд хэлье.

Энэ манай энэ И-Монголиа-тай холбоотой, нууцлалтай холбоотой зүйл бол И-Монголын үндсэн сервер дата төв дээр байдаг. Дата төв бол өөрийн гэсэн нөөц төв нь Дарханд байдаг. Одоо бол бид нар 2025 онд олон улсын жишигт хүргэхийн тулд сэлгэн ажиллуулах төвийн нэмэлт тоног төхөөрөмжийг бас Байнгын хорооныхондоо танилцуулна.

Ингээд дата төв, мөн энэ кибер аюулгүй байдалтай Монгол Улсад 3 янзын төв ажиллаж байгаа. Нэг нь ТЕГ дээр байдаг Үндэсний серти төв байгаа. БХЯ байгаа. Хувийн хэвшил, иргэдийн энэ кибер аюулгүй байдалтай холбоотой олон нийтэд зөв ойлголт төрүүлж, хамгаалах үүрэгтэй Кибер аюулгүй байдалтай тэмцэх нийтийн төв бол яамны харьяанд ажилладаг.

Кибер аюулгүй байдлын зөвлөл бол Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд бас үйл ажиллагаа явуулдаг. Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга бас Золбаяр дарга ирсэн байгаа. Золоо дарга байгаа юу. Нэмж бас төсөвтэй холбоотой тайлбарыг өгөөрэй. Ер нь энэ кибер аюулгүй байдлын индексээр Монгол Улсын яг энэ салбар өөрөө бас анхаарлын төвд байгаа. Энэ кибер аюулгүй байдал бол үндэсний аюулгүй байдалтай холбоотой учраас хаанаа цоорхой байна уу гээд энэ хөндлөнгийн байгуулагаар, олон улсын яг ийм байгууллагаар кибер аюулгүй

байдлынхаа аудитыг хийлгэе гэдэг саналыг бас бид нар 2025 онд төсөвт саналаа өгсөн байгаа. Ер нь бид нэг оношоо тавиад ... /минут дуусав/

Ж.Золжаргал: 3 номерын микрофон нээж өгнө үү. Золбаяр дарга.

Кибер аюулгүй байдлын төсөв, хиймэл оюуныг тусгайлан дэмжсэн хөтөлбөр төсөв байна уу гэж бас асуусан, тийм ээ.

Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Золбаяр байна.

Гишүүний асуултад хариулъя.

Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба Монгол Улсад Кибер аюулгүй байдлын хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Ерөнхий сайдын харьяа доор үйл ажиллагаагаа явуулж байгаа.

Сая сайд маань тодорхой хэллээ. 3 төв бол харьяаллынхаа дагуу салбар салбарынхаа чиглэлүүдээр ажиллаж байгаа.

Төсвийн тухайд ярихад кибер аюулгүй байдлыг хангах гэдэг асуудал маань ер нь тухайн мэдээлэл хариуцагч бүх байгууллагуудын өөрсдийн үйл ажиллагаандаа тогтмол суулгаж өгөх ёстой ийм зардлын хэмжээний агуулга байж байгаа. Ер нь Кибер аюулгүй байдлын хуулийг хэрэгжүүлэхэд бид нарт нэн шаардлагатай 2 асуудал байгаа.

Бид хуулийн хэрэгжилтийг байгуулсан дүрэм журмуудаа баталсан. Нийтийн болон бусад төвүүд маань байгуулагдаад тодорхой хэмжээнд үйл ажиллагаагаа жигдрүүлээд явуулж байгаа болов ч одоо манай Байнгын хорооноос бас өмнөх жилийн төсвийн хүрээ дээр ч гэсэн гарч байсан нэг ийм асуудал байгаа.

Тэр маань юу вэ гэхээр байгууллагуудын 1 дүгээрт,

удирдлагуудын кибер аюулгүй байдлын талаарх мэдлэг, боловсрол, мөн кибер аюулгүй байдлын чиглэлээр нийт төрийн албан хаагч болон иргэдийн мэдлэг дутмаг байгаагаас кибер аюулгүй байдлаа хэрхэн хангах вэ гэдэг тал дээр тодорхой хэмжээний зардлаа төсөвлөж чадахгүй байгаа. Үүний хамгийн эхний шаардлага нь жишээлбэл бид нар лицензтэй программ хангамжийг ашиглах ёстой байгаа.

Мөн бүх кибер цахим төхөөрөмжтэй ажиллаж байгаа иргэн болон албан хаагч өөрөө кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэдлэгтэй байх ёстой. Үүнийг хангахын төлөө ААН, иргэн бүгд анхаарлаа хандуулах ёстой байгаа. Энэ чиглэлийг хангах талаар ажлын алба нийтийн төвүүдээр дамжуулаад хариуцаад явж байгаа.

Кибер аюулгүй байдлын талаар хөрөнгө оруулалтыг цэвэр нэг мэдээллийн технологийн хөрөнгө оруулалт гэсэн чиглэлээр шийдвэр гаргагч нар бүх шатдаа ингэж ойлгож явж байгаа.

Үүнийг нэлээн өндөр түвшинд авч үзэхгүй бол ер нь 7 хоног тутам гардаг тайлан мэдээгээр 80-100 мянган кибер халдлага зөрчил байж болзошгүй ийм хандалтуудыг ОУБ-аас бид нар хамтын ажил ажиллагааны хүрээнд авдаг. Энэ бол Монгол Улсын хэмжээнд 8000-аас тухайн үеийн цаг үеэс хамаараад 8000-9000 ай ни ... /минут дуусав/

Ж.Золжаргал: 3 номерт нэмэлт хугацаа өгнө үү.

Ч.Золжаргал: Гарч ирдэг. Энэ хаягийг бид нар яг энэ хаягийн цаана ямар байгууллага, ямар этгээд энэ халдлагад өртсөн байна вэ гэдэг тал дээр хамтарч ажиллах чиглэлийн эхний ээлжид нийтийн төвөөрөө дамжуулаад бид нар хийгээд, Монгол Улсын бүх интернэтийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудтай хоорондоо уялдааныхаа хүрээнд нууцын

зэрэглэлтэйгээр мэдээллээ солилцоод ингээд явж байгаа.

Энэ маань ер нь яг халдварт өвчний вирустэй яг ижил төрлийн юм байгаа. Энэ нэг газар халдварт авагдсан байх юм бол бид нар цаг хугацаа алдахгүйгээр шуурхай арга хэмжээ аваагүйгээс тэр хортой код нь бусад сүлжээгээр нь дамжиж иргэдийн мэдээлэл болон санхүүгийн болон бусад мэдээллүүдэд халдаж, бодит хохирол учруулах, мөн үндэсний аюулгүй байдалд холбогдолтой ийм мэдээллүүдийг алдах ийм эрсдэлүүд маш өндөр байдаг.

Тэгэхээр энэ тал дээр бид тодорхой саналуудыг шат шатандаа бүх яамнууд ч гэсэн энэ дээр нэлээн анхаарлаа тавиад, төсөв төлөвлөгөөгөө гаргаад явуулдаг. Гэхдээ энэ дээр яг шийдвэр гаргалтын түвшинд энэ яг ИТ-ийн нэг системийн хөрөнгө оруулалт байна гэдэг байдлаар орхигдож ирж байсан. Ийм түүхүүд байгаа.

Ноднин жилийн төсвийн хэлэлцэж байх үе дээр ч гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр энэ кибер аюулгүй байдлыг хамгаалах чиглэл дээр анхаараач гэсэн төсвийн асуудлуудыг бас тодорхой гишүүдээс хөндөөд явж байсан.

Тэгэхээр бас энэ дээр манай шийдвэр гаргагч нар маань нэлээн чухал анхаарал хандуулж, энэ кибер аюулгүй байдлыг хангаж байгаа тал дээр анхаарал хандуулах шаардлагатай гэдгийг тодотгож хэлье.

Ж.Золжаргал: Та нөгөө асуусан асуулт нь тодорхой төсөв, кибер аюулгүй байдал дээр тийм зүйл байхгүй. Салбар бүр тус тусдаа дотор нь орчихсон шингэчихсэн байгаа гэж хариулж байна шүү дээ, тийм ээ.

Ч.Золбаяр: Тийм, кибер аюулгүй байдалд нийтийн төв болон ажлын алба нь урсгал зардлынхаа хүрээнд л тодорхой

төсөвтэй байгаа болохоос энд хөрөнгө оруулалтын төсөв байхгүй.

Ж.Золжаргал: Галбадрах гишүүн танд тодруулах шаардлага байхгүй юу.

Баярлалаа. Ажлын хэсгийнхэн тийм, хиймэл ой оюуны талаар, хиймэл оюуны хэрэглээг дэмжсэн тодорхой хөтөлбөр, төсөв байгаа юу гэж асуусан байгаа.

Баатархүү сайд нэмэлт хариулт өгье.

Ц.Баатархүү: Сая Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуулиар Боловсролын яам дээр байсан тодорхой чиг үүргийг 2 яам руу өгсөн гэдгийг бүгдээр мэдэж байгаа.

Манай дээр бол инновац, энэ хиймэл оюуныг хөгжүүлэх чиглэлээр инновацийн экосистемийг бүрдүүлэх, тэгээд хиймэл оюун, их өгөгдлийг боловсруулах ийм хэлтэс байгуулагдсан. Өнгөрсөн жилийн 2024 оны төсөв дээр цахим шилжилт арга хэмжээний үед хиймэл оюун ухааны чиглэлээр ажиллаж байгаа хувийн хэвшилүүдтэй бид нар хамтран ажиллах тодорхой төсвүүд хийгдээд, ингээд хамтын ажиллагаанууд явж байгаа.

Цаашидаа бид нар И-Монголиа-аас гадна ер нь энэ хувийн хэвшилүүдийг дэмжиж, хамтарч ажиллах энэ бодлогыг яам гаргаж байгаа. Хувийн хэвшил нэг хөгжүүлэлт хийж байхад нь татвар төлөгчдийн мөнгөөр төр зэрэгцээ ийм яг ижилхэн программ хангамж хийдэг энэ явдлыг таслан зогсооё.

Бид нар рок лицензийн төлбөр төлдөгтэй адилхан дотоодын энэ софт верд дээр ч гэсэн лиценз төлөөд, төр, хувийн хэвшил бас ашиглаж болох энэ юм руугаа орох нь хамгийн зөв юм байна гэж үзээд хувийн хэвшилүүдтэй жишээ нь яам 5 дахь өдөр Баасан гараг болгон уулзаж,

сонсож, танилцаж Монголд амжилттай ажиллаж байгаа энэ компаниудтай ажиллаж байгаа.

Бид нар яах вэ, төсвийн үеэр ярих байх. Энэ виртуал бүсийн асуудал буюу энэ салбарын татварын хөнгөлөлт үзүүлэх энэ хууль, эрх зүйн орчин бүрдсэн. Гэхдээ Сангийн яам, Монголбанк бусад яамнуудтай ойлголцож ажиллах ийм шаардлага байгаа гэдгийг дахин хэлье. Тийм төслүүдэд хөгжүүлээд явж байгаа гэдгийг хэлье.

Ж.Золжаргал: Нэмэлт мэдээлэл өгөхөд, нөгөө Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд хиймэл оюуныг дэмжих том заалт орсон байгаа. Тэр дагах журмууд нь энэ парламентын бүрэн эрхийн үед гараад, ингээд хэрэгжээд явах болов уу гэж хүлээж байгаа. Тийм.

Тэгээд нөгөө ажлын хэсгийнхэндээ хэлэхэд энэ гишүүдийн асуултад нөгөө өргөн хүрээнд мэдээж, танин мэдэхүйн мэдээлэл өгөх нь сайн хэрэг. Гэхдээ гол асуултад нь хариулчхаад, дараа нь нэмэлт дэлгэрэнгүй мэдээлээ өгнө үү гэж хүсье.

Дараагийн асуулт Ундрам гишүүн. Микрофон нээж өгнө үү.

Ч.Ундрам: Инновац, цахим бодлогын байнгын хороо 2020 онд байгуулагдсан. Тэгээд агентлагаа бид нар яам болгоод явж байгаа. Ер нь сүүлийн үед энэ технологийн эрин үед бид нар энэ цахим бодлогогүйгээр явах ямар ч аргагүй болсон. Цаашилаад бүх салбар луу хиймэл оюун ухаан гээд орж ирж байна.

Тэгэхээр бид нар энэ Байнгын хороо, энэ яаман дээр Улсын Их Хурлын гишүүд анхаарлаа хандуулж, маш нухацтай ажиллах ёстой гэж бодож байгаа. Гэтэл өнөөдөр ингээд Байнгын хорооны ирцээс авхуулаад л өчнөөн ард түмний итгэлийг авч, сонгогдож бөөн олон олон том том юм ярьж гарч

ирчхээд, ирцдээ хүртэл ингээд орохгүй, хуралдаа суухгүй, хоцордог, ийм хариуцлагагүй байж болохгүй гэдгийг бас энд хэлмээр байна.

Тэгээд энэ дээр бас Байнгын хорооны дарга, салбарын сайд ч гэсэн анхаараасай гэж бодож байна. Өнгөрсөн хугацаанд 2020-оос 24 онд бид нар энэ салбартай холбоотой бүх хууль, эрх зүйн орчныг шинэчилж, УИХ маш шаргуу ажилласан. Салбарын яам ч гэсэн борви бохисхийлгүй ажилласан байгаа. Энэ дараагийн 4 жил бид нар хэрэгжүүлэлт дээр анхаарах ёстой. Тэгээд өнгөрсөн хугацаанд миний зүгээр нэг харамсдаг юм нь энэ эрүүл мэндийн салбарт бид нар том программ оруулж ирэхээр Дэлхийн банкнаас санхүүжилт аваад, эрүүл мэндийн салбарыг цахимжуулах ийм том төсөл орж ирсэн байдаг. Тэгээд үүний мөнгөө буцаагаад хураалгачихсан. Яагаад вэ, гэхээр нөгөө төслийг нь идэж уугаад, завхруулаад байхгүй болгочихсон. Холбогдох албан тушаалтнууд.

Тэгэхээр яг энэ ямар явцтай явж байгаа вэ? Үүнийг шалгаж байгаа хүн байна уу? Үүнтэй холбоотой асуудалд орооцолдсон ямар ямар албан тушаалтнууд байдаг юм бэ? Хариуцлага хүлээсэн хүн байдаг юм уу. Тэгээд цаашид энэ эрүүл мэндийн салбарынхаа цахим руу шилжих ажлыг та хэд яаж төлөвлөж байгаа юм. 23 онд яг юу юу хийгдсэн юм бэ? Энэ дээр маш тодорхой тоо баримттай мэдээлэл авмаар байна.

Ж.Золжаргал: Баярлалаа. Мөнхсайхан сайд, бид түрүүн бас энэ талаар санал солилцож байсан. Энэ талаар салбарын яамнаас мэдээлэл өгөх үү. Баатархүү сайдын микрофоныг нээж өгнө үү.

Ц.Баатархүү: Би Ундрам гишүүний яг 1 дүгээр асуултад арай хариулах эрхгүй байх гэж бодож байна. Тэр хариуцлага тооцоод явж байгаа юм дээр. Би зүгээр яг мэдээлэлтэй байгаад

өгөхдөө нэг хариулах эрхгүй байх гэж бодож байна.

2 дугаар асуулт дээр “Цахим эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд ЭМЯ манай яам 2 хамтарсан ажлын хэсэг гарсан. Өмнө нь ийм бас ажлын хэсэг гараад ажлууд явж байгаа. Хамгийн 1 дүгээрт, бид нарын хийхээр төлөвлөж байгаа юм бол энэ эмийн бүртгэлийн асуудал байгаа. Нөгөө хуурамч эм, жинхэнэ эмийг нөгөө ялгаж өгөөч гэдэг хүсэлт иргэдээс их ирдэг юм байна.

Тэгэхээр эрүүл мэндийн салбарынхантай уулзсан. Чинбүрэн гишүүний ч хэлж байгаа гол зүйл юу юм гэхээр тэгээд түүнийг ер нь ямар систем дээр хийх юм бэ гэхээр одоо бол зүгээр ингээд бүртгэл дээр оруулчихсан байгаа. Гэхдээ нөгөө гарал үүслийн нэг үнэ нь замдаа өөрчлөгдөхгүй хийх технологи бол өөрөө блокчэйн юм байна. Тэгэхээр Засгийн газар дээр бид нар энэ удаа ерөөсөө блокчэйн технологи дээр энэ эмийн бүртгэлийг хийгээд, яг энэ хуурамч эм, жинхэнэ эмийг иргэд нь ч тэр, яам нь ч тэр, хүлээж авч байгаа тал нь ч ялгадаг, ангилдаг болж чадах юм бол энэ хамгийн 1 дүгээр дэвшил байх юм байна гэж үзэж байгаа.

Мэдээж хэрэг тэр олон улсын шугамаар хийж байсан ажлууд дээр хууль, хяналтын байгууллага ингээд үнэн зөвийг нь тогтоогоод явж байгаа. Ямар ч байсан төсөв нь татагдчихсан юм байна лээ. Төсөв нь татагдчихсан. Одоо бидний хамтын ажиллагаа бол ямар нэгэн төсөвгүйгээр Засгийн газар дээр үүрэг чиглэл өгчихсөн учраас 2 яам хамтарч ажлын хэсэг байгуулаад, эмийн бүртгэлийн ажлыг явуулж байгаа.

Ер нь эрүүл мэндийн салбарт 34 ширхэг софтвер байна. Интеграц болохгүй байна. Өөр өөрийн гэсэн нэлээн амбицтай гэж хэлэхээр буруу үг сонгоцхож байх шиг байна. Ингээд явдаг ийм бүр бүртгэлийн системтэй. Үүнийг нэгтгэх талаар бас эрүүл мэндийн

салбарынханд бид нар ойлголт өгөөд, ажлын хэсэг гараад ингээд явж байгаа. Ер нь цахим шилжилт бүх салбарт хэрэглэгдэж байна. Хамгийн их хэрэглээтэй байгаа нь эрүүл мэндийн салбар, боловсролын салбар 2 байгаа учраас эрүүл мэндийн салбар дээр яам бол манай яамны зүгээс өөрсдийнхөө чиг үүрэг, боломжийн хүрээнд ингэж ажиллаж байгаа гэдгийг дуулгая.

Сангийн яам юм уу бусад газраас л тэр эхний асуултад хариулах байх.

Ж.Золжаргал: Эхний асуулт гэдэг нь та тэр эрүүл мэндийн төслийг ярьж байна уу, тийм ээ. 19 сая долларын төсөл хэрэгжих гээд мөнгөө буцаагаад татчихсан гэсэн шүү дээ. Амжаагүй. Тэр тал дээр мэдээлэл өгөх боломжтой ажлын гишүүн. 1 номерын микрофон нээж өгнө үү.

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг Ундрам гишүүний асуултад хариулъя.

“Цахим эрүүл мэнд” гээд энэ Дэлхийн банкны санхүүжилттэй төсөл маань анх 19 сая доллароор эхлээд, төслийнх нь явц нь явж байгаа. Тэр яг саяын таны ярьдаг тэр хууль хяналтын байгууллагаар шалгагдсан нь тэр 2 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдсэн цахим эрүүл мэндийн платформын ажил байсан.

Тэгээд энэ дээр Солонгосын гүйцэтгэгч компани шалгараад тэр компани нь ажлаа хийж явж байгаад ер нь Сангийн яамнаас бол яах вэ, 30 хувийн санхүүжилт авсан байдаг. Тэгээд ажил нь тэр тухайн үед ЭМЯ захиалагчийн яамнаас нь хийгдсэн гэдэг байдлаар ирсэн.

Дараа нь хууль, хяналтын байгууллага ороод тухайн ажил нь яг бодит гүйцэтгэл нь гараагүй байна гэдэг үндэслэлээр АТГ-ын хууль, хяналтын байгууллага ороод, сая тэр Солонгосын

гүйцэтгэгч компани үндсэндээ авсан байсан 1,7 сая доллароо эргээж төвлөрүүлсэн байгаа.

Энэ Дэлхийн банкнаас ч гэсэн манай Сангийн яаманд шаардлага ирээд энэ санхүүжилтийг заавал эргээж Дэлхийн банканд төл өө гэсэн шаардлага ирсэн. Үүнийх нь дагуу Солонгос компанийнх нь талаас өөрсдөө тэрийг хүлээн зөвшөөрөөд, эргээж манай Сангийн яаманд төлбөр орж ирээд, манай Сангийн яамнаас эргүүлээд тэр төлбөрийг Дэлхийн банк руу шилжүүлсэн байгаа. Энэ талаар бас та анзаарсан бол АТГ-аас нэг сая төлөгдсөн доор нь хэвлэлийн мэдээ эд нар яваад гарч байсан. Тийм. Ийм нөхцөл байдал байгаа. Төсөл бол түрүүн сайдын хэлдгээр 22 оны 9 сарын 30-ны өдөр хаагдсан.

Тэгээд түүнээс хойш ямар нэгэн санхүүжилт бид нар гаргаагүй. 22 оны 9 сард хаагдсан байдлаар гүйцэтгэл нь ингээд зогссон байгаа гэсэн үг. Тийм.

Ж.Золжаргал: Ундрам гишүүн микрофон нээж өгнө үү. Тодруулга.

Ч.Ундрам: Энэ 19 сая долларын төсөл бас аягүй харамсалтай байхгүй юу. Бид нар алдагдсан боломжийн өртгөө тооцох юм бол тийм ээ, энэ салбарт бүтэн бас энэ программ хангамжийн цахимжуулах ийм хөтөлбөр хэрэгжээд, үр ашгаа өгөөд ард иргэдэд энэ нь бас хэрэгтэй ийм ажил болоод явах байсан боловч бид нар хэчнээн тэр компаниар нь мөнгөө төлөвлөсөн ч гэсэн алдагдсан боломжийн өртгөө бид нар хэзээ ч нөхөж чадахгүй.

Тэгээд Дэлхийн банк нэгэнт ийм асуудалтай юм бид нар хийчихсэн болохоор дараагийн санхүүжилтээ ч гэсэн тийм ээ, бараг хийхгүй, өгөхгүй тийм л байдалтай бид нар гадаад ертөнцөд өөрсдийгөө их муухайгаар харуулж байна л даа.

Тэгэхээр үүнийг ямар ч л байсан энэ холбогдох яамд нь бүрэн энэ хариуцах хүмүүсийг нь хариуцлага тооцуулах ёстой шүү. Дахиж хэзээ ч ийм юм гарахгүй байдал дээр анхаарч ажиллах ёстой. Үүний чинь үр дүнд ард иргэд хохироод байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ дээр маш хатуу хариуцлага тооцох ёстой шүү гэдгийг анхааруулж хэлмээр байна.

Ж.Золжаргал: Баярлалаа. Ундрам гишүүний эхний юу асуулт биш, үг хэллээ гэж ойлгосон. Тийм. Байнгын хорооны ирцийн хувьд.

Тэгээд ер нь Байнгын хорооны 2 дахь хурал явагдаж байгаа. Би ажлын албатай яриад дотоод сүлжээгээр нэг 5 удаагийн хурлын ирцийг яагаад, бүртгэлийг нь хийгээд өөрсдөд нь танилцуулаад ингээд явъя гэж бодож байна. Энэ чинь яах вэ, түүний хувьд ирцийн хувьд зүгээр найрсгаар хэлээд та ирэхгүй бол больчихооч гэж нэг болно. Тэгээд үгүй бол тэгээд Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороонд хандаж, тийм арга хэмжээ авагдах байх л даа, тийм ээ. Тэгээд тодорхой хэмжээнд бас бид нар цаг хугацаагаа харж байгаад ер нь хариуцлагатай ажиллах ёстой гэдгийг бас давтаж хэлмээр байна.

Цэнгүүн гишүүн асуултаа асууна уу.

С.Цэнгүүн: Сайн байцаана уу. Энэ эрчим хүчний реформтой холбоотойгоор бид нар үнэ, үнэ тарифыг өртөгт нь хүргэнэ гэж ярьж байгаа юм. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор иргэдийн нэг айдас нь болохоор маш өндөр тарифтай болчих юм биш үү. Бид нар ингээд эрчим хүчний хэмнэлт хийж чадахгүй, иргэн өөрөө хэдий хэр хэмжээний өртөгтэй эрчим хүч хэрэглэж байгаа авъя гэдгийг мэдэхгүй байхад бид нар ингээд шууд нэг дүнгүүдийг сар болгонд нь гаргаад

явчихаар иргэдэд аягүй айдастай байж байгаа юм.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор бид нар энэ нөгөө нэг ухаалаг тоолуурын системийг ярих шаардлагатай болчихоод байгаа юм. Улаанбаатар цахилгаан түгээх компани дээр 2023 онд болохоор ухаалаг цахилгаан, ухаалаг тоолуурын төсөл хэрэгжээд явж байгаа юм байна лээ.

Тэгээд энэ дээр болохоороо 460 мянган айл дээр энэ ухаалаг тоолуурыг суурилуулах юм бол 4 жилд бараг 80-аад тэрбум төгрөг ерөнхийдөө хэмнэлтийг хийгээд энэ төсөл маань өөрөө амжилттай явах боломжтой гээд дүгнэлт нь гарчихсан байгаа юм байна лээ. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор нэг жил энэ тоолууруудаа эхнээс нь авхуулаад тавьчихсан байгаа.

Үүний дата мэдээлэл нь Цахим хөгжлийн яам дээр ирсэн байгаа болов уу. Яагаад вэ гээд тэгэхээр бид нар эрчим хүчний реформоо хийхэд үүнтэй холбоотой мэдээллүүд аягүй их хэрэгтэй. Яагаад гэхээр тоолууруудаас бид нар маш олон датануудыг цуглуулах боломжтой. Яг үүнээс харахад үнэхээр яг хөнгөлөлт шаардлагатай байгаа айлууд нь хаана байгаа юм.

Дээрээс нь эсвэл хэрэглээ өндөртэй байгаа ААН эсвэл айлууд хаана байгаа вэ гэдгээ ингээд зураглалаа гаргаж ирэхэд маш хэрэгтэй дата энд цугларсан юм байна гэж хараад байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр ер нь Инновац, цахим хөгжлийн яам ямар бодлоготой ажиллаж байгаа бол?

Дээрээс нь энэ цахилгаан түгээх дээр хэрэгжсэн төсөл нь болохоороо өөрөө нэг 80-аад тэрбум орчим төгрөгийн нөгөө нэг төсөл юм байна лээ. Тэгээд үүнийг цаашир нь хэрэгжүүлээд явахад эсвэл үүнийг ганцхан цахилгаан дээр биш дулаан дээр бид нар бас оруулж өгөх шаардлагатай байгаа. Дулааны

тариф дээр бас яагаад гэвэл иргэд маань өөрсдөө заавал 22, 23 градустай өндөр нөгөө нэг халуун, дулаан байлгах гэхээс илүү өөрөө байрандаа дотроо үүнийг нөгөө нэг шийдчих боломжийг нь гаргаж өгөх юм бол бид нар нөгөө цахилгааны, дулааны хэмнэлт гаргаж өгөөд, энэ нөгөө эрчим хүчний реформоо хийхэд маш түлхэц болох зүйл байгаа юм л даа. Тэгэхээр 2023 оноос эхлээд хэрэгжиж байгаа энэ төслийн дата мэдээллүүд байгаа юу гэж 1-д асууя.

Дараа нь болохоороо ер нь бид нар үүнтэй холбоотойгоор шийдвэр гаргахад бас туслаад ажиллаад явах боломж бололцоо юу байгаа бол. Яагаад гэхээр эдийн засгийн үр өгөөж нь энэ тоолуурууд маш өндөр байгаа юм гэдэг нь харагдчихсан байна л даа 2023 оны тайлангаас харахаар.

Ж.Золжаргал: Алтан-Од дарга 4 номер.

Цэнгүүн гишүүний асуултад хариулъя, Алтан-Од.

Яг эрчим хүчний салбартай холбоотойгоор тэр мэдээлэл дамжуулах нөгөө сүлжээ либералчлах асуудал өнгөрсөн нөгөө операторын интернэтийн үйлчилгээ эд нар гээд тэр мэдээллүүд яам дээр нэгтгэгдэж ирсэн мэдээлэл байхгүй. Одоогоор өнгөрсөн жилийн гүйцэтгэл дээр төсөв хөрөнгө юм уу, хамтын ажиллагааны хувьд яасан зүйл байхгүй байгаа.

Ж.Золжаргал: Цэнгүүн гишүүн нэмэлт тодруулга байна уу? Цэнгүүн гишүүний микрофон нээж өгнө үү. Цэнгүүн гишүүний микрофон нээж өгнө үү.

С.Цэнгүүн: Тэгэхээр энэ нөгөө биг дата цуглуулах ажил байгаа шүү дээ. Бид нар энэ ухаалаг тоолууруудаа нэг суурилуулаад явчих гэхээс илүү маш олон чухал мэдээллийн дата бааз үүсэж байгаа. Тэгэхээр энэ баазаа бид нар

хаанаа цуглуулах юм бол. ҮСХ дээр энэ цуглардаг байх юм уу. Бид нар аль талдаа авч явдаг байх вэ?

Ж.Золжаргал: Баатархүү сайдын микрофон.

Ц.Баатархүү: Цэнгүүн гишүүний хөндөж байгаа асуудал аягүй зөв асуудал л даа. Ер нь энэ мэдээллээ хаана нэгтгэх вэ гээд. Тэгээд Байнгын хороон дээр төр засгийн олон ажил хэрэгч хүмүүс сууж байна л даа. Мэдээллээ шийрлээд юм уу, дундын dashboard руу нөгөө өгөгдлөө өгөх тийм таатай ханддаг газар цөөхөн байдаг юм байна лээ.

Тэгээд Засгийн газар Учрал сайд хуучин энэ яамыг удирдаж байсан учраас Хэрэг эрхлэхийн сайд байгаа учраас хүчээр бид нар энэ мэдээллүүдээ интеграц хийе гэдэг ийм шийдэл рүү орж байгаа. Жишээ нь, энэ яам болгон та нар Засгийн газрын ингээд бүтцийг харах юм бол яам болгон доороо ийм мэдээллийн төвтэй болчихсон. Мэдээллийн төв гэдэг нь датагаа нэгтгэдэг түүнийг ингээд таблю дээр ч юм уу, повер ти ай дээр dashboard-оо ингээд угсардаг ийм төвтэй. Тэгээд үүнийг Сангийн яам дээр, татвар, санхүүгийн мэдээллийн төв, Боловсролын яам дээр бас ийм мэдээллийн төв байж байдаг. Ингээд цахим яам байдаг. ЭМЯ дээр байж байдаг. Бүх яам, агентлаг өөрөө ингээд мэдээллээ боловсруулдаг нэгжтэй болчихсон юм байна.

Тэгээд нэгж нь ингээд нэгдсэн ингээд мэдээллээ хоногийн алдагдалгүй өгдөг энэ dashboard-ыг угсрах гээд бид нар яваад байгаа юм. Тэгээд манай яам юм уу, энэ танай яам мэдээллээ өгөөч гэхээр шууд өгчихдөггүй л юм байна лээ л дээ. Тэгээд энэ ингээд Засгийн газрын хурлаараа ингээд бид нар үүрэг өгөөд, аваад, ингээд мэдээллийг нэгтгээд ингээд явж байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

Тэгээд эхний dashboard гарахаар тэр эрчим хүчний dashboard ямар

мэдээллүүд, нөгөө иргэдийн гар утсан дээр бэлэн байх уу гэдэг ийм бас ярьж байгаа. Тэгээд Цэнгүүн гишүүний түүнийг энэ ухаалаг тоолуур, ухаалаг энэ цахилгааны тоолуур, бас энэ халуун хүйтнээ хэмжих энэ смарт хоттой холбоотой энэ олон ойлголтуудыг хэлж байгаа.

Яамны зүгээс ирэх 7 хоногоос эхлээд бүх яам дээр бид нар очиж уулзаж байгаа. Ямар ажлуудаа ингээд нийлүүлж, нэгтгэж, хамтарч хийх вэ. Хамтарсан ажлын хэсэг гаргах вэ гэж. Тэгэхгүй бол жилийн дараа Байнгын хорооны хурал дээр энэ цахимжилтын үр дүнг зөвхөн ингээд манай яамнаас нэхэх магадлал байдаг юм байна. Гэтэл ихэнх ... /минут дуусав/

Ж.Золжаргал: Та нэмэлт цаг авах уу. Баатархүү сайдын микрофон нээж өгнө үү.

Ц.Баатархүү: Тэгээд хамгийн 1 дүгээрт, бид нар ирэх 7 хоногт Улаанбаатар хотын удирдлагатай уулзаад энэ нөгөө Смарт лайт гээд ухаалаг энэ гэрэл. Тэгээд энэ замын түгжрэлтэй холбогдуулаад энэ гэрлэн дохионы асуудал, ингээд смарт хоттой холбоотой төслүүд явдаг. Бүгдээрээ тус тусдаа ийм төслүүдийг хэрэгжүүлэх ийм сонирхол байгаа. Энэ бол нууц биш. Үүнийг бид нар уялдуулах юм бол мөнгө хэмнэнэ, уялдуулах юм бол үр дүн их хурдан гарна.

Тийм учраас манай яамны зүгээс бүгдэд нь уулзах урилга хүргүүлээд, тэгээд арга зүйн зөвлөмж л үзүүлж байгаа. Тэгээд Засгийн газрын хуралд орж танилцуулах ийм дэг жаягтай байгаа гэдгийг хэлье.

Тэгээд таны энэ авсан тайлан юм бол албан ёсоор яаман дээр байхгүй байгаа. Тэгээд энэ чиглэлээр илүү бид нар бас ЭХЯ-тай хамтарч ажиллаж байгаа. Зүгээр хамгийн түрүүнд бид нар Зам, тээврийн яамтайгаа ажиллаад нөгөө нэг

хөдөө орон нутагт нэг цаасаар билет авдаг байсан юм бол энэ 100 хоногтоо больж байгаа шүү. Ямар ч байсан бид нар 100 хоногтоо шууд шууд шийдэж болох ажлуудаа шийдчихье. Одоо цахим болсон гэсэн хөдөө зун явлаа, билет цаасаар авч байна энэ тэр гээд олон шүүмжлэлүүд ирж байгаа. Энэ болгоныг бид нар ингээд хүлээж авч байгаа. Тэгээд та бүхнийхээ, Байнгын хорооны гишүүдийн хэлж байгаа бүх саналуудыг хүлээн авлаа. Яг таны хэлсэн дата манайд байхгүй байгаа шүү.

Ж.Золжаргал: Баярлалаа. Та хариулт авав уу.

Би нэмээд бодлоо хуваалцахад мэдээж цахим хөгжил гэдэг нэг тусдаа салбар биш бүх салбар дээр байгаа. Тийм болохоор салбар хоорондын шийдлүүд, ялангуяа энэ Цахим хөгжлийн яам байгуулагдаад, Байнгын хороо бий болоод энэ 4 дэх жил, 5 дахь жилд орж байна уу даа, тийм ээ. Харьцангуй шинэ. Тэгэхдээ цаашидаа ер нь салбар хооронд маш их асуудлууд байгаа нь харагдаад байгаа.

Эрчим хүч ялангуяа Диспетчерийн үндэсний төв дээр нийт сүлжээний тооцоолол, таазыг ингээд маш сайн хийгээд бүр эй ай түвшинд хийдэг болсон маш ололттой зүйлүүд байдаг. Цэнгүүн гишүүний хэлж байгаа дулааны тоолуурууд, цахилгааны ухаалаг тоолуурууд, микро гэрээ, ухаалаг сүлжээ гээд хүмүүс дээвэр дээр бас эрчим хүч үйлдвэрлэдэг болно. Тэгэхээр үүнийг дагаад хиймэл оюун ашиглах, цахимжуулах, автоматжуулах, их том бас ийм шинэ зүйл гарч ирэх гээд байна. Ойрын жилүүдэд эрчим хүчний реформыг дагаад.

Тэгээд үүнд бас манай салбарынхан бэлтгэлтэй байх ёстой байх л даа. Тэгээд Баатархүү сайдын хэлж байгаагаар энэ салбар хоорондын уулзалтууд их чухал байх гэж бодож байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой үг хэлэх гишүүд байвал нэрс өгнө үү? Үг хэлэх гишүүн байхгүй байна.

Уучлаарай, Галбадрах гишүүн үг хэлэх.

Ингээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Галбадрах Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулна. Танд баярлалаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 23 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дуусгалаа.

16.13 цаг

Хуралдаан хаасныг мэдэгдье.

Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Гишүүддээ баярлалаа.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ